



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 423

Улаанбаатар хот

Улаанбурхан өвчний
дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.13, 8.1.21 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулах түр зааврыг нэгдүгээр, Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын нэгдсэн хүснэгтийг хоёрдугаар, Улаанбурханы эсрэг нэг цэнт вакциныг хэрэглэх зааврыг гуравдугаар, Улаанбурхан өвчний үед эрүүл мэндийн байгууллагад баримтлах халдварын сэргийлэлт, хяналтын зааврыг дөрөвдүгээр, Улаанбурханы дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэгдүгээр хавсралтаар баталсан түр зааврын дагуу Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулан улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг товллын дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны хүүхдүүдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тавдугаар хавсралтаар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг 2025 оны 6 дугаар сарын 20, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад үүрэг болгосугай.

141251253

4. Уг тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр)-д, цахим мэдээллийн сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллахыг Стратеги төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт даалгасугай.

5. Энэхүү тушаалаар Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/344 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

05 Эрүүл мэндийн сайдын 2025 оны
..... дугаар сарын өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсад 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад аялсан өгүүлэмжтэй улаанбурхан өвчний эхний зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд улаанбурхан өвчний зөөвөрлөгдсөн 5, дотоодын нийт 4,274 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 2 тохиолдол нас барсан байна. Үүнээс 65.3 хувь (2,793) нь эмчлэгдэн эдгэрч, 12.8 хувь (551) нь эмнэлэгт, 21.7 хувь (551) нь Өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад гэрээр эмчлэгдэж байна.

Нийслэл хот болон 16 аймагт улаанбурхан өвчин голомтлон гарч, өвчлөгсөдийн насны хязгаар 3 сартайгаас 60 настай, хүйсний хувьд 55.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Насны ангиллаар харахад хамгийн өндөр хувь буюу 44.2 хувийг (1891) 10-14 насны хүүхдүүд эзэлж байна.

Бүртгэгдсэн тохиолдлын 69.1 хувь нь улаанбурханы эсрэг товлолын дархлаажуулалтад 5.6 хувь дархлаажуулалтын нас болоогүй тохиолдлууд эзэлж байгаа бол 17 хувь нь улаанбурханы эсрэг 2 тунд хамрагдсан, 8.3 хувь нь 1 тунд хамрагдсан байна.

Монгол Улсад улаанбурханы В3 хэвшинжийн үүсгэгчээр үүсгэгдсэн дэгдэлт бүртгэгдэж байна.

Хоёр. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалт

2.1. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед халдвараас сэргийлэх, тархалтыг хязгаарлах, өвчлөл, хүндрэл, нас баралтаас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтыг зохион байгуулна.

2.2. Эрүүл мэндийн байгууллагууд харьяа аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвөөс шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийг татан авна.

2.3. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед нэн тэргүүнд дараах зорилтот бүлгийг улаанбурханы эсрэг дархлаажуулалтад хамруулна. Үүнд:

- Эрүүл мэндийн ажилтнууд;
- Батлагдсан тохиолдлын хавьтал;
- Товлолын дархлаажуулалтад хамрагдаагүй 16 хүртэлх насны хүүхэд;
- Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг вакцины товлолын нас хүрээгүй 6-8 сартай хүүхэд;

Эрүүл мэндийн ажилтнуудыг дараах байдлаар дархлаажуулна.

2.3.1. Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан болон өвдөж байсан эсэх нь тодорхойгүй эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнуудыг улаанбурхан, улаануудын (УУ) эсрэг вакцины нэг тунгаар дархлаажуулна.

2.3.2. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж буй оюутнууд болон дайчлагдан ажиллаж буй резидент эмч нарыг улаанбурхан, улаануудын (УУ) эсрэг вакцины нэг тунгаар дархлаажуулна.

2.4. Батлагдсан тохиолдлын хавьтлыг 72 цагийн дотор дараах байдлаар дархлаажуулна.

Хавьтлын дархлаажуулалтын байдал	Нас	Тариулах вакцин
Улаанбурхан өвчнөөр өвдсөн эсэх болон улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан эсэхээ мэдэхгүй ЭСХҮЛ улаанбурхан өвчний эсрэг вакцины (УУ эсвэл УГУ) 1-р тунд хамрагдсан бол	16 наснаас дээш	УУ вакцины 1 тунгаар дархлаажуулах
УГУ вакцины 1, 2-р тунд хамрагдаагүй, улаанбурхан өвчнөөр өвдөж байгаагүй бол	16 хүртэлх насны хүүхэд	“Нөхөн дархлаажуулалт хийх журам”-ын дагуу дархлаажуулах*
Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг (УГУ) вакцины 1-р тунд хамрагдсан боловч 2-р тунд хамрагдаагүй бол	16 хүртэлх настай хүүхэд	
Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдаагүй, улаанбурхан өвчнөөр өвдөж байгаагүй нь тодорхой бол	16 хүртэлх насны хүүхэд	
Товлолын дархлаажуулалтад бүрэн хамрагдсан ч эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлтээр сайн дурын дархлаажуулалтад хамрагдах	18 хүртэлх насны хүүхэд	УУ вакцины 1 тунгаар
Вакцины зааврын дагуу дархлаажуулалтын эсрэг заалттай хүн, жирэмсэн эмэгтэй, 6 хүртэлх сартай хүүхдэд улаанбурханы эсрэг вакцин хийхгүй.		

*-Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаал

2.5. Улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг вакцины товлолын нас хүрээгүй 6-8 сартай хүүхдийг дархлаажуулна. Үүнд:

2.5.1. Улаанбурхан өвчний батлагдсан тохиолдолтой хавьтал болсон 6-8 сартай хүүхдийг дархлаажуулахаас өмнө эмчийн үзлэгийг нарийвчлан хийж, биеийн байдлыг үнэлэн суурь өвчин, цочмог болон архаг халдваргүй тохиолдолд хавьтал болсноос хойш 72 цагийн дотор эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр сайн дурын үндсэн дээр (үнэ төлбөргүй) улаанбурханы эсрэг (У) вакцины нэг тунгаар дархлаажуулна.

Гурав. Тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт

3.1. Улаанбурханы өвчний тархвар судлалын нөхцөл байдал, улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг (УГУ) вакцины дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралтын хувь, эрсдэлийн үнэлгээний үр дүн, Халдварт өвчинтэй тэмцэх мэргэжлийн төв байгууллагын саналыг үндэслэн тархвар судлалын заалтаар дараах зорилтот бүлгийг дархлаажуулна. Үүнд:

3.1.1. Улаанбурхан өвчин бүртгэгдэж буй гадаад улс оронд зорчих улаанбурханы эсрэг дархлаажуулалтад хамрагдсан баримтгүй 3 ба түүнээс дээш насны иргэдийг УУ вакцины 1 тунгаар;

3.1.2. Халдвар тархах эрсдэл өндөртэй орчин (оюутан, сурагчдын дотуур байр, цэргийн анги, асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, хорих анги, уул, уурхайн ажилчдын амрах байр, кэмп г.м)-д амьдардаг иргэдийг УУ вакцины 1 тунгаар;

3.1.3. Товлолын нас хүрээгүй 6-8 сартай хүүхдийг улаанбурханы эсрэг (У) вакцины нэг тунгаар дархлаажуулсаны дараа товллын дагуу 9 сартай, 2 настайд УГУ вакцинаар дархлаажуулах ба тун хоорондын зай 1 сараас багагүй байна.

Дөрөв. Дархлаажуулалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэлт

4.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нь дархлаажуулалтын хамралт, вакцины нөөцийн мэдээг ажлын өдөр бүр 17 цагаар тасалбар болгож, 18 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанд цахим програм болон утсаар мэдээлнэ.

4.2. Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн болон вакцинатор нь дархлаажуулалтын цахим бүртгэлд зөвхөн өөрийн эрхээр нэвтрэх ба мэдээллийн санд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

4.3. Харьяалах хүн амын дунд улаанбурханы эсрэг вакцины бүрэн тунд хамрагдаагүй 16 хүртэлх насны хүүхдийг илрүүлж, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 дүгээр тушаалын дагуу товллын УГУ вакцинаар нөхөн дархлаажуулж дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn>)-д бүртгэнэ.

4.4. Эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд болон улаанбурхан өвчин батлагдсан тохиолдлын хавьтал, УГУ вакцины товллын нас хүрээгүй 6-8 сартай хүүхдийн тархвар судлалын заалтаар дархлаажуулагдсан мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn>)-д бүртгэнэ.

4.5. Мэдээллийн сангийн үнэн зөв байдалд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

4.6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын алба нь улсын хэмжээний дархлаажуулалтын хамралт, үнэн бодитой байдал, дархлаажуулалтын цахим сангийн хөгжүүлэлтэд хяналт тавьж, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангана.

----000----

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
... дугаар сарын ... өдрийн ... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ

Дархлаажуулалтын хэлбэр	Нас	Товлол (УГУ)		Нэмэлт (УУ)	Нөхөн, дэгдэлтийн үеийн			
		I тун	II тун		УГУ I	УГУ II	УУ	У
Товлолт дархлаажуулалт*	9 сар, 2 нас	Заавал хийх үндэсний товллын дагуу дархлаажуулна.						
Нөхөн дархлаажуулалт*	3-15 нас	+	+	-	Шаардлагагүй			
		+	-	+		Тийм		
		+	-	-		Тийм		
		-	-	-	Нөхөн		-	-
Хавьтлын дархлаажуулалт (72 цагийн дотор)	6-8 сар	-	-	-	-		-	Тийм
	3-15 нас	+	+	+	Шаардлагагүй			
		+	+	-	Шаардлагагүй			
		+	-	+		Тийм		
		+	-	-	Нөхөн			
		-	-	-	Нөхөн			
	16-аас дээш	+	+	+	Шаардлагагүй			
		+	+	-				
		+	-	+				
		-	-	-				
	Эрүүл мэндийн ажилтан		+	+	+			
+			+	-				
+			-	+				
+			-				Тийм	
-			-				Тийм	

Тайлбар:

(+) - Вакцин тариулсан

(-) - Вакцин тариулаагүй

(Тийм) - Вакцин тариулах шаардлагатай

(Шаардлагагүй) - Вакцин тариулах шаардлагагүй

(Нөхөн) – Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261-р тушаал баримтлана.

(*) – Улаанбурухан өвчнөөр өвдсөн бол өвдсөнөөс хойш сарын зайтай хийнэ.

---000---

УЛААНБУРХАНЫ ЭСРЭГ НЭГ ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Улаанбурханы амьд, сулруулсан (хөлдөөж, хатаасан) вакцин нь хүний диплойд эсэд өсгөвөрлөж, улаанбурханы (Эдмонстон-Загреб) омгийн вирусээс гаргаж авсан.

Вакцин нь хөлдөөж хатаасан хуурай, тусгай уусгагч шингэнтэй. Цайвар шаргал өнгө бүхий хуурай хатаамал юм. ДЭМБ-ын шаардлага TRS840 (1994) аргачлалыг хангасан ба 10 хүн тунгаар савлагдсан.

Нэг хүн тун буюу 0,5 мл вакцин нь дараах найрлагатай:

Улаанбурханы вирусийг 1000 CCID₅₀-аас багагүй агуулна.

Хэрэглэх арга ба тун, бусад вакцинтай харилцан үйлчлэл:

- Улаанбурхан өвчний эсрэг идэвхтэй дархлаа тогтоох зорилгоор хүүхдийг 6-8 сартайд нь гуяны булчинд тарьж дархлаажуулна.
- Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, гепатит В, хемофилүс инфлюэнза В) вакцин, Халдварт саагийн уудаг болон халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин, шар чичрэгийн эсрэг вакцин, А витаминтай цуг хэрэглэж болно.
- Бусад вакцин хоорондын зай 1 сар, иммуноглобулин болон цус сэлбүүлсэнээс хойш 3 сарын дараа уг вакциныг хийнэ.
- Улаанбурханы эсрэг (У) вакцины 1 тунд хамрагдсан 6-8 сартай хүүхэд товллын дагуу улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг (УГУ) вакцины 1-р тунд 9 сартайд, 2-р тунд 2 настайд хамрагдана.

Тарих арга:

Вакциныг найруулахдаа нэг удаагийн ариун зүү, тариур хэрэглэн зөвхөн вакциныг дагалдаж ирсэн уусгагч шингэнээр найруулна. Уусгагчийг хийж зөөлөн сэгсрэхэд нунтаг бодис хялбар уусна. Найруулсан вакциныг зөөлөн сэгсэрсний дараа өөрөө эвдэрдэг зориулалтын нэг удаагийн тариурт 0,5 мл-ээр соруулан авч, гуяны гадна хэсгийг 3 хуваасны гадна дээд болон дунд хэсгийн заагт 90°C өнцгөөр булчинд тарина.

Вакциныг найруулахын өмнө вакцин болон уусгагч шингэнд гадны ямар нэг биет байгаа эсэхийг харж, заавал шалгана. Хэрэв гадны биет байвал вакцин, уусгагч шингэнийг хэрэглэж болохгүй.

Хариу урвал:

1. Вакцин тариулсны дараа хэсэг газрын хөнгөн урвал болох тарьсан хэсэг газарт бага зэрэг хавдах, улайх, хөндүүрлэх урвал гарч 1-3 хоногт ямар нэг эмчилгээгүй хэвийн байдалд орно.
2. Вакцин хийлгэснээс хойш 7-12 хоногт тариулсан хүмүүсийн 5-15%-д бага зэрэг халуурах, 2%-д нь хөнгөн хэлбэрийн туурах шинж илэрч 1-2 хоног үргэлжилж болно.
3. Вакцины давтан тунгийн дараа хэсэг газрын хөнгөн урвал ховор илэрнэ.

4. Анафилаксийн урвал маш ховор илрэх ба мэдрэг хүмүүст вакцин хийлгэснээс хойш 24 цагийн дотор чонон хөрвөс, загатнах, харшлын тууралт гарч болно.

Вакцин хийлгэсний дараа анафилаксийн хариу урвал илрэх үед авах хариу арга хэмжээний яаралтай тусламж (тоног төхөөрөмж, эм, тариа)-ийн бэлэн байдлыг хангасан байх ёстой.

Эсрэг заалт:

Дараах тохиолдолд вакциныг тарьж болохгүй. Үүнд:

- Кортикостеройд, бусад төрлийн дархлаа дарангуйлах эм, туяа эмчилгээний үед
- Лейкеми, хурц цус багадалт, цусны тогтолцооны бусад цочмог өвчин, бөөрний үйл ажиллагааны хурц дутагдал
- Декомпенсацийн шатанд буй зүрхний өвчнүүд
- Гаммаглобулин хийлгэсэн эсвэл цус сэлбүүлсэн тохиолдолд хоорондын хугацааг нягтлан харах
- Вакцины найрлаганд орсон бодисоос харшилтай
- Өндөр халуунтай, цочмог халдварт өвчний үе
- Жирэмсэн эхэд хийхийг тус тус хориглоно

Хадгалах нөхцөл:

- Вакциныг шууд тусах гэрлээс хамгаалж +2 - +8°C хэмд хадгална.
- Уусгагч шингэнийг ХӨЛДӨӨЖ БОЛОХГҮЙ.
- Найруулсан буюу задалсан вакциныг тэр даруйд нь хэрэглээгүй тохиолдолд +2- +8°C хэмийн зориулалтын хадгалах хөргөгч, зөөврийн саванд 6 цагаас илүүгүй хадгалан, зохих журмын дагуу устгана.

Үйлдвэрлэгч: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Серум институт компани.

----000----

**УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГАД БАРИМТЛАХ ХАЛДВАРЫН
СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗААВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагат улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, эрэмбэлэн ангилах, тусгаарлах, халдвар тархахаас сэргийлэх, эрүүл мэндийн ажилтан үйлчлүүлэгч нарыг халдварт өртөхөөс сэргийлэхэд дараах зааврыг мөрдөнө.

1.2. Тус зааврыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан, резидент эмч, оюутан, захиргаа, дэмжих үйлчилгээний ажилтан зэрэг эрүүл мэндийн байгууллагын үндсэн болон гэрээт бүх ажилтан баримталж ажиллана.

**Хоёр. Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх,
эрэмбэлэн ангилах**

2.1. Амбулатори, хүлээн авах, яаралтай тусламж зэрэг үйлчлүүлэгч нэвтрэх хэсэг, үүдэнд "Дуугүй хөтөч" эсвэл хөтөч ажилтан ажиллуулна.

2.2. "Дуугүй хөтөч" болон хөтөч ажилтан нь улаанбурхан өвчний шинж тэмдэг илэрсэн сэжигтэй үйлчлүүлэгчийг эрт илрүүлж тусад нь зохион байгуулсан үзлэгийн хэсэгт чиглүүлэх үүргийг гүйцэтгэнэ.

2.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотойгоор халдвар тархахаас сэргийлж улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлын үзлэгийн хэсгийг тусад нь зохион байгуулна.

2.4. Үзлэгийн хэсэг нь гаднаас орох тусдаа хаалгатай, олон хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу, агааржуулалт сайтай, гарын ариун цэвэр сахих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.5. Эмнэлэгт бөөгнөрөл үүсгэхээс сэргийлж үзлэгийн цагийг утсаар болон цахимаар олгох, халдварт өртөх эрсдэлтэй бага насны хүүхэд, жирэмсэн эхийн үзлэг, тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх, халдварын шинж тэмдэг илэрсэн сэжигтэй тохиолдлыг эмнэлэгт ирүүлэхгүйгээр дуудлагын дагуу гэрт нь очин үзлэг оношилгоог хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулна.

2.6. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд товлолын дархлаажуулалт болон 0-1 насны хүүхдийн хяналт, үзлэгийн хуваарьт өөрчлөлт оруулж, гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх эсвэл эмнэлэгт олон хүнтэй хавьтал болохоос сэргийлж тусдаа өрөөнд үзлэг хийхээр зохицуулна.

2.7. Байгууллагын орох хаалга, хүлээлгийн хэсэг, цайны газар, цахилгаан шатны дэргэд зэрэг олон хүн цуглардаг газарт амьсгалын замын халдвараас сэргийлэх санамж, зөвлөмж, анхааруулгыг байрлуулан түгээнэ.

2.8. Эрүүл мэндийн байгууллага нь амьсгалын замын халдварын тархалтаас сэргийлэх, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр баримтлах холбогдох тушаал, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллана.

Гурав. Улаанбурхан өвчний сэжигтэй, батлагдсан тохиолдлын тусгаарлалт, тээвэрлэлт

3.1. Өрхийн эрүүл мэндийн төв, клиник нь Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/81 дүгээр тушаалын дагуу өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарах улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлыг тусгаарлан, ХӨСҮТ, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд мэдэгдэж, өвчтөнийг шилжүүлэх арга хэмжээ авна.

3.2. Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах үед үйлчлүүлэгчид нэг удаагийн амны хаалт зүүлгэнэ.

3.3. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/81 дүгээр тушаалын дагуу өндөр эрсдэлтэй бүлэгт хамаарах улаанбурхан өвчний батлагдсан тохиолдлыг тусгаарлаж эмчилнэ. Нэг нэгээр нь тусгаарлах боломжгүй нөхцөлд улаанбурхан өвчний онош батлагдсан өвчтөнүүдийг хамт тусгаарлана.

3.4. Сэжигтэй тохиолдлыг батлагдсан тохиолдолтой хамт тусгаарлахгүй, онош батлагдах хүртэл ганцаараа байхаар зохицуулж, тус тусад нь тусгаарлан эмчилнэ.

3.5. Хэрэв улаанбурханаар өвдсөн жирэмсэн эх амаржих тохиолдолд халдвартын эмнэлэг, тасагт тусгаарлаж төрүүлнэ. Амаржсан эхийн халдвартай үеийг дуусах хүртэл нярайг эхээс тусгаарлах ба энэ хугацаанд эхийн сүүг сааж хэрэглэнэ.

3.6. Тусгаарлах өрөө нь агаарын сөрөг даралттай, агааржуулалт сайтай, хаалга байнга хаалттай, гадагш гарсан хаалгатай, дотроо ариун цэврийн өрөө, гарын угаалтууртай байна.

3.7. Тусгаарлах өрөөний гадна талд анхааруулах тэмдэглэгээ тавина.

3.8. Улаанбурхан өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг тусгаарласан эмнэлэгт эргэлт оруулахыг хориглоно.

3.9. Тусгаарлалтын үед өвчтөнийг өрөөнөөс гарахгүй байхаар зохион байгуулна. Өвчтөнд зайлшгүй шаардлагатай оношилгоо, эмчилгээ хийх, яаралтай тусламж үзүүлэх зорилгоор өрөөнөөс гаргах болон зөөвөрлөхөд нэг удаагийн амны хаалт зүүлгэнэ.

3.10. Халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг зайлшгүй зөөвөрлөх, шилжүүлэх тохиолдолд урьдчилж хүлээн авах эрүүл мэндийн байгууллага тасаг нэгжид нь мэдэгдэнэ.

3.11. Халдварын батлагдсан, сэжигтэй тохиолдлыг тээвэрлэсний дараа машины цонх, хаалгыг нээж агаар сэлгэлт хийнэ. Машиныг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

3.12. Улаанбурхан өвчний сэжигтэй, батлагдсан тохиолдолд хэрэглэж буй давтан хэрэглэдэг багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал, орчны цэвэрлэгээ, хог хаягдлын менежментийг хүчин төгөлдөрх мөрдөж байгаа тушаал, зааврын дагуу гүйцэтгэнэ.

3.13. Батлагдсан, сэжигтэй тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн ажилтан нь улаанбурхан өвчнөөр өвдсөн, улаанбурханы вакцинд хамрагдсан байна. Хэрэв эрүүл мэндийн ажилтан улаанбурхан өвчнөөр өвдөөгүй, вакцинд хамрагдаагүй, эсвэл мэдэхгүй тохиолдолд шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ.

3.14. Аэрозол үүсгэх ажилбар (бронх дурандах, интубац тавих, авах, соруулга хийх гм) хийх бол шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ.

3.15. Тусгаарлалтын үйл ажиллагаанд халдвартын эмч, тархвар судлаач, чанарын албаны ажилтнууд тогтмол хяналт тавина;

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагад улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Хэвтэн эмчлүүлэгчдээс халдварын сэжигтэй тохиолдол илэрсэн үед тусгаарлах өрөөнд шилжүүлэн лабораторийн шинжилгээнд сорьц авч, шинжилгээний хариу гартал эмчилгээг үргэлжлүүлнэ.

4.2. Батлагдсан тохиолдлын хавьтлыг 24 цагийн дотор илрүүлж, голомтын цар хүрээг тогтоон, хяналтад авна.

4.3. Тухайн тасаг нэгж нь нийтийн ариун цэврийн өрөөтэй, сэргээн засах, цагийн тариа зэрэг тусламж үйлчилгээг эмчилгээний өрөөнд цуглуулж хийдэг бол тасгийн нийт үйлчлүүлэгчийг хавьтлаар бүртгэж авна.

4.4. Халдварын эрсдэл, цар хүрээг тооцохдоо эмнэлгийн агааржуулалтын систем, орох гарах гарц, цахилгаан шатны хүртээмж, орны эргэлт, ар гэр, сахиур, эргэлтээр ирэгсдийн хөдөлгөөн зэргийг харгалзан үзнэ.

4.5. Хавьтлыг тогтоох тархварзүйн судалгаанд эрүүл мэндийн ажилтан, дадлагажигч, үйлчлүүлэгч, өвчтөн сахиур, эргэлтээр ирэгсэдийг хамруулж, тандана.

4.6. Батлагдсан тохиолдлын халдвартай байх хугацаанд хүлээн авах, амбулаторт хамт үйлчлүүлсэн, хэвтэн эмчлүүлэх тасаг, хэсэгт хамт эмчлүүлсэн, эмнэлгээс гарсан, одоо эмчлүүлж байгаа, өөр эмнэлэг, тасаг нэгжид шилжсэн эсэхийг тодруулж, хавьтлыг тогтооно.

4.7. Хавьтал гэж тогтоосон үйлчлүүлэгчийг эмнэлэгт тусгаарлаж, үндсэн тусламж үйлчилгээг үзүүлэх ба халдварын нууц үеийн хугацааны туршид өдөр бүр шинж тэмдгийн тандалтад хамруулна. Тухайн тасаг хэсэгт шинээр хүн нэмж хэвтүүлэхгүй, өөр давхар, тасаг хэсэгт хүлээн авахаар зохион байгуулна.

4.8. Халдвартай хүнтэй хавьтал болсон, улаанбурханы эсрэг дархлаатайг нотлох баримтгүй өвчтөнийг хавьтал болсноос хойш 72 цагийн дотор дархлаажуулна.

4.9. Эмчлүүлэгчийг эмнэлгээс гарахад нь өвчний картад хавьтал болсон тухай тэмдэглэн харьяа эрүүл мэндийн байгууллагад утсаар мэдээлж, халдварын нууц үеийн хугацааг дуустал хяналтад шилжүүлнэ.

4.10. Халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх тусгаарлах хэсгийг, үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгээс тусад нь зохион байгуулна.

4.11. Хавьтал болсон үйлчлүүлэгч халдварын нууц үеийн хугацаанд эмнэлэгт дахин хэвтэх үед тусгаарлаж хэвтүүлнэ.

Тав. Эрүүл мэндийн ажилтан халдварт өртсөн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Эрүүл мэндийн ажилтны улаанбурхан өвчнөөр өмнө нь өвдсөн эсэх, вакцинд хамрагдсан судалгааг нотолгоонд үндэслэн гаргана. Улаанбурхан өвчнөөр өвдөж байгаагүй, вакцинд хамрагдаагүй ажилтан бүрийг тархвар судлалын заалтаар дархлаажуулна.

5.2. Улаанбурхан өвчний шинж тэмдэг илрээгүй, улаанбурханы эсрэг дархлаатайг нотлох баримттай эрүүл мэндийн ажилтанд:

5.2.1. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ авахгүй

5.2.2. Ажлаас чөлөөлөх шаардлагагүй

5.2.3. Улаанбурханы халдвартай эхний хавьтал болсноос хойш 5 дахь өдрөөс эхлэн сүүлийн хавьтлын 21 дэх өдөр хүртэл шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийнэ.

5.3. Улаанбурхан өвчний шинж тэмдэг илрээгүй, улаанбурханы эсрэг дархлаатайг нотлох баримтгүй эрүүл мэндийн ажилтанд:

5.3.1. Хавьтал болсноос хойш 72 цагийн дотор дархлаажуулна.

5.3.2. Улаанбурханы эсрэг товллын болон нэмэлт дархлаажуулалтад хамрагдсан тухай нотлох баримтгүй ЭСВЭЛ дархлаатайг нотлох баримтгүй ЭСВЭЛ улаанбурхан өвчнөөр өвдөж байсан тухай нотлох баримтгүй ажилтныг УУ ВАКЦИНЫ НЭГ ТУНГААР дархлаажуулна.

5.4. Улаанбурханаар өвчилсөн нь батлагдсан эсвэл улаанбурханы сэжигтэй эрүүл мэндийн ажилтныг тууралт эхэлснээс хойш 4 өдрийн хугацаанд ажлаас чөлөөлнө.

5.5. Дархлаа дутмагшилтай, улаанбурханаар өвчилсөн нь батлагдсан эсвэл улаанбурханы сэжигтэй эрүүл мэндийн ажилтныг өвчин үргэлжлэх хугацааны турш ажлаас чөлөөлнө.

Зургаа. Эрүүл мэндийн ажилтныг сургах

6.1. Эрүүл мэндийн ажилтнуудад халдварын сэргийлэлт хяналтын талаар сургалт зохион байгуулна.

6.2. Ажил үйлчилгээ, гардан үйлдлийн онцлогт тохирсон улаанбурханы халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээний талаар давтан сургана.

6.3. Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шүүлтүүртэй амны хаалт болон хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэхэд сургаж, дадлагажуулах, зөв өмсөж, аюулгүй тайлахад хяналт тавина.